



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА...../Д.ДЭЛГЭРСАЙХАН/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

*2021 оны 06 сарын 20
(огноо)*

Төлөвлөгөө тайлагнасан:

Төсвийн Шууд захирагч

ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ...../Б.САЙХАНТУЯА/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

*2021 оны 06 сарын 20
(огноо)*

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<p align="center">НЭГДҮГЭЭР ЗОРИЛГО: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ /Алсын хараа -2050” зорилт 5.3, 7.4, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, 7.4, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, “ Дундговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр”-ийн 4.1.1.7/</p>							
<p align="center">Зорилт 1. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулна</p>							
1.1.1	Улсын бүртгэлийн хэлтсийн барилгыг төсөвт суулгуулах ажлыг зохион байгуулах	Улсын төсөв 988,0 сая төгрөг	Газар эзэмших эрхийн гэрээний хугацааг сунгасан эсэх: -Барилгын төсвийг улсын төсөвт суулгуулах талаар Аймгийн засаг дарга болон холбогдох УИХ-ын гишүүдэд албан бичиг хүргүүлсэн эсэх.	Барилга барихад шаардлагатай бичиг баримт бүрэн.	Улсын төсөвт санхүүжилт суулгах бэлтгэл ажил хангагдсан байна.	Улсын бүртгэлийн байгууллагын хэлтсийн байр барих газрын зөвшөөрөл 2020 онд дууссантай холбогдон ГХБХБГазарт газрын эрх сунгах хүсэлтийг албан тоотоор хүргүүлэн шийдвэрлүүлсэн. УБЕГазрын санхүүгийн хэлтсээс барилгын зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлтийг ХЗДХЯамны мэргэжилтэнд хүргүүлэх чиглэл өгсний дагуу зургийг скайнердаж хүргүүлсэн.	
1.1.2	Бүртгэлийн үйлчилгээний танхимд цахим төлбөрийн “Гэрэгэ”-системийг хэрэглээнд нэвтрүүлэх	4,0 сая Орон нутгийн төсөв болон бусад үүсвэр эх	-Гэрэгэ систем нэвтэрсэн эсэх -Орон нутгийн удирдлага болон холбогдох УИХ-ын гишүүдэд хүсэлт хүргүүлсэн эсэх.	байхгүй	Цахим төлбөрийн систем нэвтэрсэн байна.	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний 70 хувийг бүртгэлийн үйлчилгээний танхимаар хүргэдэг бөгөөд бүртгэлийн үйлчилгээний төлбөрийг банк руу явж тушаалгадаг нь иргэдэд үйлчилгээний шат дамжлага, цаг хугацааг нэмэгдүүлж байгаа нь иргэдээс шүүмжлэл дагуулдаг.	

						Иймд үйлчилгээний танхимд цахим төлбөрийн “Гэрэгэ систем”-ийг байршуулснаар энэ хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж үзэж АЗДҮА-ны хөтөлбөр, ХЗСайдын гэрээнд тус тус тусгуулсан. “Гэрэгэ систем” ХХКомпанитай холбогдон үнийн судалгааг хийж Аймгийн Засаг даргад танилцуулаад байна.	
1.1.3	Иргэний бүртгэлийн мэдээллийн санд төрөлтийн бүртгэл алдаатай, дутуу бүртгэгдсэн 8200 иргэний зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах	-	-Мэдээллийн санд арилсан зөрчлийн тоо	2020 онд 680 төрөлтийн бүртгэлийн зөрчил арилгасан	2050 зөрчил арилсан байна.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэл технологийн газраас мэдээллийн санд төрөлтийн бүртгэл алдаатай, дутуу бүртгэгдсэн 18-аас доош насны 8200 хүүхдийн бүртгэлийг аймгийн хэмжээнд гаргуулан авч зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Жилд 2050 хүүхдийн төрөлтийн бүртгэлийн зөрчлийг арилгахаар төлөвлөн иргэний улсын бүртгэгчдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган нэг бүртгэгч 120 зөрчлийг анхан шатны журнал бүртгэл иргэдийн гар дээр байгаа бичиг баримтад үндэслэн жагсаалтаар иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн зөрчлийг арилган ажиллаж байгаа бөгөөд эхний хагас жилийн байдлаар 270 хүүхдийн төрөлтийн бүртгэлийг мэдээллийн санд зөрчилгүй болголоо.	
1.1.4	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ, мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагаа,	-	Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанаас шалтгаалсан доголдлыг	2020 онд хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжид давхардсан	Улсын бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан, техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа хангагдсан байна.	“Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн нэгдсэн сүлжээг боловсронгуй болгох” төслийн хүрээнд 2021 оны 01 сарын 6 ны өдөр тус аймгийн Хулд, Луус сумдыг бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбох ажил хийгдэж тус аймгийн 15 сумд бүрэн сүлжээнд	

	<p>аюулгүй байдлыг хариуцах, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах</p>		<p>арилгасан тоо;</p>	<p>тоогоор нийт 4 удаа засвар үйлчилгээг хийсэн.</p>		<p>холбогдлоо. Баянжаргалан, Өлзийт сумдын сүлжээний рутерт гэмтэл учирсан, Дэрэн сумын зургийн аппарат эвдэрснийг УБЕГазрын Тамгын газарт албан бичгээр хүргүүлсэн. УБЕГазраас шийдвэрлэх хугацаанд Луус сумын улсын бүртгэгч тэтгэвэрт гарч тоног төхөөрөмжийг аймгийн төвд татан авч хадгалсан байсан бүртгэлийн үйлчилгээг хэвийн тасралтгүй байдлыг хангах үүднээс Баянжаргалан суманд сүлжээний тоног төхөөрөмжийг, Дэрэн суманд зургийн аппаратыг түр хугацаагаар ашиглуулж байсан. Эрдэнэдалай, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Өлзийт сумын хэрэглээний компьютерийг форматалж принтер, сканнер таниулж хүлээлгэн өгсөн. Баянжаргалан сумын сүлжээний рүтерийг УБЕГ-ын Мэдээлэл технологийн ажилтан Төртогтохтой холбогдож засварлуулахаар ажиллаж байна. Өлзийт сумын медиа конвертерийн тогны залгуур шатсаныг сольж өгөв.</p>	
<p>1.1.5</p>	<p>Хэлтсийн үйлчилгээний танхимд цахим үйлчилгээний булан бий болгох</p>	<p>-</p>	<p>-Цахим үйлчилгээний булангаар үйлчлүүлсэн иргэдийн тоо;</p>	<p>-.</p>	<p>Цахим буланг үйл ажиллагаанд хэрэглэж эхэлсэн байна.</p>	<p>E-mongolia төрийн үйлчилгээний цахим системийг сурталчлах, иргэд өөртөө үйлчилгээ авах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор улсын бүртгэлийн үйлчилгээний танхимд интернет сүлжээ, компьютер, принтер зэргийг байршуулан “Цахим үйлчилгээний цонх”-ыг нээж ажиллуулж байна. Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаа авах иргэний үнэмлэх хаяж үрэгдүүлсэн иргэдэд заавар зөвлөмж өгч ажиллаж байна. Нийт 45 иргэн</p>	

						цахим үйлчилгээний цонхоор үйлчлүүлсэн байна. Төрийн үйлчилгээний цахим машинаас эхний хагас жилийн байдлаар 2496 лавлагаа үйлчилгээг иргэд авсан бөгөөд хамгийн их авсан нь иргэний үнэмлэх, төрөлтийн бүртгэл, гэрлэлтийн бүртгэл, үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа 60 гаруй хувийг эзэлж байна.	
1.1.6	Үйлчилгээний төлбөр, хураамжийг цахим машин, төлбөрийн системээр авах нөхцлийг бүрдүүлж, сурталчилан ажиллах	-	-Цахим машин, төлбөрийн системээр хийгдсэн төлбөр хураамжийн тоо; -Сурталчилсан байдал;	2020 онд И-баримт апп, Киоск цахим төлбөрийн машинаар 257 иргэн үйлчилгээ авсан.	Цахим хэлбэрээр төлбөр төлсөн иргэдийн тоо нэмэгдсэн байна.	Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 сарын 23 - ны өдрийн 230 дугаар тогтоолоор Улсын бүртгэлийн үйлчилгээний үнэ хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолын хэрэгжилтийг 2021 оны 07-р сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Иймээс иргэдэд Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг сурталчилж, үнийн талаарх мэдээллийг иргэдэд ил байршуулан ажиллана. Бүртгэлийн үйлчилгээг хууль, дүрэм, журмын дагуу явуулахын зэрэгцээ burtgel.mn , burtgel.gov.mn , e-mongolia зэрэг сайтуудаас мэдээлэл хэрхэн авах, киоск төлбөр төлөх цахим машинаар төлбөр төлөх талаар нарийвчилсан зөвлөлгөөг өдөр тутам өгч ажилласан. 2021 онд И-баримт апп, Киоск цахим төлбөрийн машинаар 112 иргэн үйлчилгээ авсан байна.	
ХОЁРДУГААР ЗОРИЛГО: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ							
Зорилт 2. Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлнэ.							

2.2.1	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх.	-	-Бүртгэл хөтөлсөн тоо; -Бүртгэлийн үйлчилгээ авсан иргэдийн тоо	2020 онд Иргэн-9297, ХЭ-553, Эд хөрөнгө 2514 бүртгэл хөтөлсөн	Улсын бүртгэл үнэн зөв хөтлөгдөж, иргэдэд хүртээмжтэй хүрсэн байна.	<p>Иргэний гэр бүлийн бүртгэлийн төрөлтийн бүртгэлд 423, гэрлэлт 67, гэрлэлт цуцлалт 12, эцэг тогтоолтын бүртгэлд 10, овог нэр өөрчлөлт 8, нас баралт 104, иргэний үнэмлэхийн бүртгэл 868, гадны аймаг хотоос бүрмөсөн шилжин ирсэн 134, аймаг доторх шилжилт хөдөлгөөний бүртгэлд 384, гадаад паспортын бүртгэл 62 нийт 2072 бүртгэл хийсэн.</p> <p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд 308 анхны бүртгэл, эрх шилжүүлэх 222 бүртгэл, бүртгэлд өөрчлөлт 48, барьцааны гэрээ 1287 нийт 1865 бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл дахин гэрчилгээ олгосон 23,Нэмэлт өөрчлөлт хийсэн 78,Лавлагаа олгосон 209,</p> <p>Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр хяналтын дугаар олгосон- 44, шашны байгууллага хугацаа сунгасан-1, хураан авсан -14, шинээр хуулийн этгээд бүртгүүлсэн-24, татан буугдсан 3 бүртгэлийг бүртгэж, нийт 396 бүртгэл хийж нийт 4333 улсын бүртгэл хөтөлсөн байна.</p>	
2.2.2	Бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмж, техник хэрэгслийг УБЕГ азраас шинэчлэх ажлын хүрээнд сумдад олгох ажлыг зохион байгуулах	-	-Тоног төхөөрөмж шинэчлэгдсэн бүртгэгчдийн тоо	2010 оноос хойш шинэчлэгдээгүй	-Тоног төхөөрөмж шинэчлэгдсэн байна. -Бүртгэлийн үйлчилгээг хэвийн тасралтгүй хүргэх боломж бүрдсэн байна.	<p>Хэлтсийн нийт 25 албан хаагчдын 24 нь буюу 96 хувь нь Ажлын байрны таатай орчины сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдлаа.</p> <p>Албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийн түвшин болон ажлын сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлж, холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг авлаа. Хэлтсийн нийт 25 албан хаагчдын 24</p>	

						<p>нь буюу 96 хувь нь ажлын байрны таатай орчины сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдлаа.</p> <p>Судалгааг</p> <ol style="list-style-type: none"> 1. Ажиллах орчин 2. Харилцаа хандлага, ёс зүй 3. Сэтгэл зүйн орчин зэрэг үндсэн гурван агуулгын хүрээнд 13 асуулт боловсруулан судалгааг авлаа. <p>Судалгааг нэгтгэхэд ажлын байрны ая тухтай орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах тал дээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ёс зүйн харилцаа хандлагыг сайжруулах, мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдах шаардлагатай байгаа талаар албан хаагчдын дийлэнх нь санал нэгдсэн байна.</p> <p>Мөн тоног төхөөрөмж хуучирсан иргэдэд бүртгэлийн үйлчилгээ явуулахад хүндрэлтэй байгаа тул тоног төхөөрөмжийн шинэчлэлийг яаралтай хийх шаардлагатай байна.</p> <p>Эхний хагас жилд УБЕГазраас 2 ш скайнер, коронавирусын эрсдлээс урьдчилан сэргийлэх агаар ариутгагч 5 ширхэг төхөөрөмж өгснийг бүртгэлийн үйлчилгээний танхим, эд хөрөнгийн ахлах, Сайнцагаан сумын бүртгэлийн үйлчилгээний өрөө зэрэг хамгийн их үйлчлүүлэгч ирдэг газруудад хуваариллалаа.</p>	
2.2.3	Байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлд зөрчилтэй	-	- Хаягийн зөрчил арилсан тоо	Хаяг өөрчлөх шаардлагатай 155 иргэн	Говь-Угтаал сумын 4-р багийн иргэдийн хаяг	Говьугтаал суманд баг шинээр нэмэгдсэнтэй холбоотой баг нэмсэн тухай сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын	

	иргэдийн зөрчил арилгах ажлыг зохион байгуулах.				шинэчлэгдсэн байна.	тогтоолын хамт 155 иргэний хаягийг мэдээллийн санд өөрчлөх талаар УБЕГазрын иргэний улсын бүртгэлийн газарт жагсаалтыг хүргүүлсэн боловч сонгуулийн үйл ажиллагаатай холбоотойгоор хаягийн өөрчлөлтийг тусгах боломжгүй тухай хариуг ирүүлсэн тул 7 сард багтаан тус сумын 4 дүгээр багийн иргэдийн хаягийг Иргэний улсын бүртгэлийн газар болон Мэдээлэл технологийн газарт жагсаалтыг хүргүүлэн хаягийн өөрчлөлтийг оруулна.	
2.2.4	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэлжүүлж, гэрчилгээ олгох	-	-Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэсэн тоо; -Олгосон гэрчилгээний тоо;	2020 онд 11 салбар төлөөлөгчийн газар бүртгэж гэрчилгээ олгосон.	Үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газар бүртгэгдсэн байна	Бүртгэгдсэн салбар төлөөлөгчийн газар байхгүй	
2.2.5	Улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэдийн хүсэлтээр мэдээлэл, лавлагаа өгөх	-	-Улсын бүртгэлтэй холбоотой олгосон мэдээлэл, лавлагаа, хуулбар, нотлох баримтын тоо; -Эрхийн улсын түтгэлзүүлсэн бүртгэлийн тоо;	2020 онд мэдээллийн сангаас нийт 2183 иргэнд лавлагаа олгосон	Улсын бүртгэлтэй холбоотой үнэн зөв лавлагаа, мэдээлэл, нотлох баримтыг хуульд заасан хугацаанд олгосон байна.	Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр мэдээллийн сангаас 1641 лавлагаа, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 62 лавлагаа, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 209 лавлагаа нийт 1912 лавлагааг иргэдийн хүсэлтийн дагуу гаргаж үйлчилсэн байна.	
2.2.6	Улсын бүртгэлийн асуудлаар төрийн болон бусад байгууллагатай харилцан мэдээлэл солилцох.		-ЭМЯ-ны мэдээллийн сангаас регистрийн дугаар унагаж бүртгэсэн төрөлтийн бүртгэлийн тоо	ЭМЯ-ны төрөлтийн мэдээллийг дундын мэдээллийн сангаар дамжуулан авч,	ЭМЯ-тай мэдээлэл солилцох боломж бүрдсэн байна.	Эрүүл мэндийн яамны мэдээллийн сангаас регистрийн дугаарыг унагаж нийт 423 хүүхдийн төрөлтийн бүртгэлийг бүртгэсэн бөгөөд регистрийн дугаар зөрүүтэй олгогдсон 2 хүүхдийн бүртгэлийг УБЕГазрын Мэдээлэл технологийн газар болон	

	/дундын мэдээллийн сан/		- ГХБХБГ-ын мэдээллийн сангаас олгосон Е дугаарын бүртгэлийн тоо	1076 регистрийн дугаар, ГХБХБГ-д 505 Е-дугаар цахимаар олгосон.		ЭМДГазарт албан тоотыг хүргүүлэн регистрийн дугаарыг засварлуулан дахин олгож бүртгэлийг хөтөлсөн. Мик актив хорин гурав ТЗК ХХК-ийн 2021 оны 03 сарын 29-ны өдрийн №21/06-20 тоотын дагуу 11 хувийн хэрэг болон нийт 1 удаагийн 11 хувийн хэрэгт тусгай тэмдэглэл хийж албан тоотыг хүргүүллээ. Дундын мэдээллийн сангаас нийт 450 Э дугаар олгож хувийн хэргийн бүрдүүлэлтийг бүрдүүлж ажиллалаа.	
2.2.7	Санхүүгийн тайланг найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг үндэслэн байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлан хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах.	-	-Улсын бүртгэлээс хассан хуулийн этгээдийн тоо	-	-Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сан цэгцэрсэн байна. -Хуульд заасан хугацааны дараа хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах бүртгэл хөтөлсөн байна.	- Хугацаа болоогүй	
2.2.8	Нотариатчийн мэдээллийн сантай холбогдон, илгээсэн мэдээллийг хүлээн авах, бүртгэх, гэрээ байгуулах, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд	-	-Нотариаттай хамтран ажилласан эсэх, -Системийг хэрэглээнд нэвтрүүлсэн эсэх	байхгүй	Бэлтгэл ажлыг хангасан байна.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулинд нотариатаар дамжуулж үйлчилгээ авах, нотариат зуучлалын үүрэг гүйцэтгэх ажил үйлчилгээ нэвтрэхтэй холбоотой аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг 2 нотариатч, сумдад нотариатын үүрэг гүйцэтгэн ажилладаг сумдын засаг	

	нотариатч зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх.					даргын тамгын газрын дарга нартай эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системийн шинэчлэлийн талаар мэдээлэл, чиглэл өгч ажиллалаа. ХЗДХЯамны сайдын зөвшөөрлийн загвар батлах, нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шинэчлэн олгох тухай тушаалыг улсын бүртгэгчдэд танилцуулан мөрдөн ажиллаж байна.	
2.2.9	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг суманд үзүүлж эхлэх бэлтгэл ажлыг хангах, судалгааг УБЕГазарт хүргүүлэх		-Суманд бүртгэсэн ЭХЭУБүртгэлийн тоо	байхгүй	Суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл бүртгэх боломж бүрдсэн байна.	Койкагийн төсөл хэрэгжиж сумдад эд хөрөнгийн эрхийн бүртгэл хийгдэж эхлэхтэй холбогдуулан суурь судалгааг тус аймгийн Эрдэнэдалай сумын иргэд, улсын бүртгэгчээс асуумжийг нэгтгэн УБЕГазарт хүргүүлсэн. Мөн Эрдэнэдалай сумын улсын бүртгэгч УБЕГазраас явуулсан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх тухай сургалтад хамрагдсан.	
2.2.10	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн хариуцлагын даатгалын гэрээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	-	- Гэрээний хэрэгжилтийн хувь;	“ХААН даатгал” ХХК-тай хамтарч бүртгэгч нарын хариуцлагын даатгал хийгдэж эхэлсэн.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарыг хариуцлагын даатгалд хамруулж, гэрээний хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Аймагт үйл ажиллагаа явуулдаг “Мөнхдаатгал” ХХК ны захирал Б.Эрдэнэцэцэгээс хэлтсийн албан хаагчдад гэнэтийн ослын даатгал сэдвээр даатгалд даатгуулахын ач холбогдол, үр дүнгийн талаар сургалт мэдээлэл авлаа. Хэлтсийн нийт 28 албан хаагчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулахаар болсон.	
2.2.11	80190003 дугаарын нээлттэй утасны чанар хүртээмжийг сайжруулж, 75052828 дугаарын лавлах утасыг хэрэглээнд нэвтрүүлэх	200000 бусад эх үүсвэр	-Утсаар лавлагаа мэдээлэл авсан иргэдийн тоо	Бүртгэлийн нээлттэй утсанд 358 иргэн холбогдож мэдээлэл авсан	Үйлчилгээний лавлах утсанд хандаж байгаа иргэдийн тоо нэмэгдэнэ.	Улсын бүртгэлийн үйлчилгээний “Бүртгэлийн лавлах-75052828” дугаарын утсыг үйлчилгээнд нэвтрүүлсэн бөгөөд иргэд улсын бүртгэгчидтэй шууд холбогдон лавлагаа мэдээллийг авах боломжийг бүрдүүлэн ажилласан. Эхний хагас жилд	

						“Бүртгэлийн лавлах- 75052828” дугаарын утсанд 46 иргэн, 80190003 нээлттэй утсанд 124 иргэний нийт 170 иргэнд лавлагаа мэдээлэл, заавар зөвлөмж өгч ажилласан байна.	
2.2.12	Бүртгэлийн хууль тогтоомжоор иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх	–	- Сургалт, мэдээлэл хүргэсэн иргэдийн тоо	Бүртгэлийн хууль тогтоомжийг фэйсбүүк, бүртгэлийн вэйб сайт, цахимаар 3500 иргэнд хүргэсэн	Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн хууль тогтоомжтой холбоотой цахим зөвлөмжийн 4 цуврал мэдээллийг бэлтгэж хүргэсэн. Нийт 760 иргэн хандалт хийж мэдээлэл авсан. Мөн улирлын зорилтын хүрээнд улсын бүртгэгчид Эрдэнэдалай, Адаацаг, Сайхановоо, Дэлгэрхангай, Дэлгэрцогт сумдын улсын бүртгэгч мэдээллийн фэйж хуудсанд хаяж үрэгдүүлсэн иргэний үнэмлэх хэрхэн авах, газар, үл хөдлөх хөрөнгийн анхны бүртгэл, компани хэрхэн бүртгүүлэх, шилжилт хөдөлгөөний бүртгэлээр “Live- мэдээлэл” хийж нийт 366 иргэн холбогдсон байна. Шинээр 16 насанд хүрч иргэний үнэмлэх авч байгаа Эрдмийн далай цогцолбор сургуулийн 10 Б ангийн 27 хүүхдэд “Бүртгэгч-багш” мэдээллийн өдөрлөг зохион байгуулан иргэний шинэчилсэн бүртгэлд хэрхэн хамрагдаж иргэний үнэмлэх авах, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийг хэрхэн ойлгох талаар мэдээлэл өгч сэдвийн хүрээнд “АХА” танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулан түрүүлсэн сурагчийг дурсгалын зүйлээр урамшууллаа.	
2.2.13	Сумдад “Бүртгэлийн нээлттэй өдөрлөг” зохион байгуулах	Сургалтын төсвийн хүрээнд	-Бүртгэлийн үйлчилгээ авсан иргэдийн тоо	Нээлттэй хаалганы өдөрлөгөөр 426 иргэнд бүртгэлийн үйлчилгээг	Бүртгэлийн үйлчилгээг хүртээмжтэй хүрсэн байна.	Дундговь аймгийн улсын бүртгэлийн хэлтэс, ТА-3 төсөл, модерн маркет ХХК-тай хамтран 2021.02.22-2021.02.26-ны өдрийн дуустал Өлзийт, Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдад	

				хүргэсэн.	<p>бүртгэлийн “Нээлттэй мэдээллийн өдөрлөг” зохион байгууллаа. Өдөрлөгөөр нийт 130 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, 88 иргэнээс бүртгэлийн үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгааг бөглүүлж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.</p> <p>Тус сумдын улсын бүртгэлийн</p> <ul style="list-style-type: none"> • 2020,2021 оны бүртгэлд хяналт шалгалт хийх, заавар зөвлөмж өгөх. • Өнгөрсөн оны бүртгэлийн баримт үдэж цэгцэлсэн эсэх, • Дотоод сүлжээний компьютерт Спарк суулгах, • Цахимжсан архивын программаас мэдээллийг хэрхэн хайж лавлагааг яаж гаргах • Шинээр онлайнд холбогдсон сумд, шинэ бүртгэгчид программууд дээр хэрхэн ажиллаж байгаа, • Ажлын байрны эмх цэгц, • Бүртгэлийн үйл ажиллагааг орон нутагт хэрхэн сурталчилж, мэдээ мэдээллийг хүргэж байгаа, • мэдээллийн самбарын баяжилт өөрчлөлт зэрэг үзүүлэлтээр хяналтыг хийж заавар зөвлөмж өглөө. <p>Цаашид бүртгэлийн үйл ажиллагааг орон нутагтаа сурталчлах, шинийг санаачилж ажиллах, хууль тогтоомжийг уншиж судалж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг үүрэг болгож гарсан зөрчил дутагдлыг газар дээр нь арилган ажилласан.</p>
--	--	--	--	-----------	--

Зорилт 3. Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулна.

2.3.1	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавих	-	- Хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь.	2020 онд нийт 2296 бүртгэлд хяналт хийсэн	Хяналт шалгалтын мөрөөр тухай бүр холбогдох арга хэмжээг авсан байна	<p>2021 оны эхний хагас жилд Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжийн хүрээнд нийт 278 шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт хийж нотлох баримтын бүрдэл дутуу байсан 23 бүртгэлийн зөрчлийг улсын бүртгэгчдээр арилгуулж ажилласан.</p> <p>Иргэний бүртгэлийн чиглэлээр 28, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 6, хуулийн этгээдийн чиглэлээр 2 нийт 36 хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргалаа.</p> <p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 03 сарын 17-ны өдрийн 8/1760 тоот чиглэлийн хүрээнд аймгийн Прокурорын газар, цагдаагийн газартай хамтран аймгийн төвийн нийт 15 дэлгүүр, барьцаалан зээлдүүлэх газруудаар хяналт шалгалт хийлээ.</p>	
2.3.2	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн зөрчлийг арилгах	-	-Зөрчилтэй иргэдийн тоо; -Зөрчлийг арилгасан тоо;	2020 онд мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн ... иргэдийн зөрчлийг УБЕГ-ын ИУБГ-т албан бичиг хүргүүлж арилгуулсан.	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн илэрсэн зөрчлийг 100% арилгасан байна.	Иргэний бүртгэлийн мэдээллийн санд төрөлтийн бүртгэлд эцэг эхийн мэдээлэл, бүртгэлийн дугаар дутуу орсон 270 хүүхдийн бүртгэлийн зөрчлийг УБЕГ газрын Иргэний бүртгэлийн газарт жагсаалтаар хүргүүлэн мэдээллийн сангийн зөрчлийг арилгалаа.	
2.3.3	Улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	-	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд гарах зөрчлийг бууруулсан тоо;	2020 онд нийт 2296 бүртгэлд хяналт шалгалт хийж, 596 зөрчил илрүүлж арилгасан.	Улсын бүртгэлийн үйлчилгээ иргэн, хуулийн этгээдэд тэгш, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүрсэн байна.	<p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 03 сарын 17-ны өдрийн 8/1760 тоот чиглэлийн хүрээнд аймгийн Прокурорын газар, цагдаагийн газартай хамтран аймгийн төвийн нийт 15 дэлгүүр, барьцаалан зээлдүүлэх газруудаар хяналт шалгалт хийлээ.</p> <p>Аймгийн засаг даргын 2021.04.24-ны</p>	

						<p>өдрийн №А/159 тоот захирамжаар барааны дэлгүүрүүд ажиллаж эхэлсэн бөгөөд барааны дэлгүүртэй хамт барьцаалан зээлүүлэх үйл ажиллагаа явуулдаг “Түмэн дэлбээ” ХХК, “Хөрх хайрхан” ХХК, “Нээ” ХХК, “Цанидноров” ХХК, “Хөрх булаг” ХХК, “Говийн манлай” ХХК гэх зургаан барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, 9 гэр хорооллын жижиг дэлгүүрүүдээр орж хяналт шалгалт хийхэд баримт бичиг барьцаалсан зөрчил илрээгүй.</p>
2.3.4	Зөрчлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах	-	<p>- Шалган шийдвэрлэсэн зөрчлийн тоо; -Иргэдэд зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг зохион байгуулсан эсэх</p>	<p>Зөрчлийн тухай хуулиар 347 иргэний үйлдсэн зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж 8,280,000 торгууль ногдуулсан.</p>	<p>Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо буурсан байна.</p>	<p>Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар харъяалуулсан зөрчлөөс Зөрчлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.4 дэх заалтын дагуу 167 иргэний үйлдсэн зөрчлийг харъяалан хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж орон нутгийн орлогод 3.990.000 мянган төгрөг төвлөрүүлсэн.</p> <p>Зөрчил шалган шийдвэрлэх тухай зөрчлийн хуулиар хэдийгээр хялбаршуулсан журмаар зөрчлийг шалган шийдвэрлэж байгаа боловч хөдөө орон нутгийн иргэдийг заавал өөрийн биеэр ирүүлэх, ломбард дэлгүүр зэрэг газруудад барьцаалсан эсэхийг нотолж байгаа үйл явц нь иргэдэд хүндрэл учруулдаг.</p> <p>Иймээс сумдын улсын бүртгэгчдийг иргэний үнэмлэх хаяж гэсэн, үрэгдүүлсэн тохиолдолд E-mongolia цахим системээр иргэдийг үнэмлэх захиалах боломжийг олгох заавар зөвлөмж өгч ажиллахыг зөвлөн ажиллаж байна.</p>

2.3.5	Аймгийн хэмжээнд иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн зөрчил арилгах ажлыг зохион байгуулах	-	Арилгасан зөрчлийн тоо;	Хаягийн зөрчилтэй 17 иргэнийг хаягтай болгож, шилжин очсон газраа бүртгүүлээгүй 48 иргэнд утсаар холбогдон бүртгүүлэхийг зөвлөсөн	Иргэний оршин суугаа газрын хаягийн зөрчлийг арилгасан байна.	Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн бэлтгэл ажлын хүрээнд аймгийн хэмжээнд мэдээллийн санд байнга оршин суугаа хаягийн бүртгэлгүй 12 иргэний хаягийн мэдээллийг шилжилт хөдөлгөөний бүртгэлээр оруулж мэдээллийн санд хаягтай болгосон.	
Зорилт 4. Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт хамгаалалтыг сайжруулна.							
2.4.1	Архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл байдлыг сайжруулах	-	Архивын стандартын хэрэгжилтийн хувь;	-	Архивын стандартын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.	<p>Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл буюу иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан ИУБ-31/А/ маягт 826 ширхэгийг иргэний баримтын төв архивд галиглан, шивж хүргүүлсэн. Мөн ИУБ-31/Б/ маягтуудыг архивд байрлуулсан.</p> <p>1951 оноос хойш төрсөн иргэдийн төрөлт болон бусад журнал бүртгэлийг шүүж, бүртгэгчийн захиалгын дагуу архиваас зохих журам, хуулийн дагуу гаргаж, архивын журнал бүртгэлийн бүрэн бүтэн байдлыг хангаж, урагдаж цоорсон, шаардлага хангахгүй болсон бүртгэлийг сэлбэн засах ажлыг өдөр тутам хийж сэргээн засварладаг.</p> <p>Мөн архивын материалын хавтаслалт, хадгалалт, хамгаалалт дотоод эмх цэгцийг сайжруулах ажлыг тогтмол хийж байна.</p> <p>Эд хөрөнгийн архивыг багтаамжийн дагуу цэгцэлж, нэмэлт өөрчлөлт орж буй хувийн хэргийг ангилан, хаягжуулж хайрцаглан байршуулсан. Эд хөрөнгийн хувийн хэргийн анхны бүртгэл 2021 оны хагас жилийн байдлаар нийт 308 ширхэг</p>	

						хувийн хэргийг архивт байршуулан ажилласан байна. Архивт хадгалагдаж байгаа иргэн, эд хөрөнгө хуулийн этгээдийн хувийн хэрэг өдөр ирэх тусам өсөн нэмэгдэж байгаагаас архивын багтаамж муудаж нэмэлт тавиур тавих боломжгүй байгаа тул цаашид стандартын шаардлага хангасан архивын байрны асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.
2.4.2	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн баримтын архивын тооллого хийж, баримтыг данс бүртгэлжүүлэх	-	-Тоолсон иргэний баримтын тоо; -Тоолсон хуулийн этгээдийн хувийн хэргийн тоо; -Тоолсон эд хөрөнгийн хувийн тоо;	Хэлтсийн архивт тус аймгийн 46 мянга гаруй иргэний хувийн хэрэг, хуулийн этгээдийн 998 , эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 15560 хувийн хэрэг	Хэлтсийн иргэний баримтын архивыг 100% тоолсон байна.	Эд хөрөнгө болон хуулийн этгээдийн бүртгэлийн баримтын архивын хувийн хэргийн тооллогыг эд хөрөнгийн тасгийн улсын бүртгэгчид, хуулийн этгээдийн бүртгэгч, архивч нар тоолж данс бүртгэлжүүлж дуусгалаа. Эд хөрөнгийн архивын хувийн хэрэг 12400, хуулийн этгээдийн архивын хувийн хэрэг 1236 нийт 13636 хувийн хэрэг хадгалагдаж байна. Иргэний баримтын архивын хувийн хэргийн тооллогыг 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.
2.4.3	Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн хувийн хэргийг цахимжуулах	-	-Цахимжуулсан хувийн хэргийн тоо	75 хувийн этгээдийн хувийн хэрэг цахимжаагүй	Хуулийн этгээдийн бүртгэл	УБЕГ-н 2021 оны 03 сарын 22 ны өдрийн Б/1890 тоо дугаартай албан бичгийн дагуу улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлгүй, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгааг хүргүүлсэн. Мөн архивт байршиж байсан шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийг хавтаслаж, татварын мэдээллийн сантай тулгалт хийж татан буулгах, бүртгэлд хамруулах ажил бүрэн хангагдаад байна.

2.4.4	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын цаасан баримтыг цахим сантай тулгалт хийх	-	-Цахим сантай тулгалт хийсэн бүртгэлийн тоо	-	Гэрээний эрхийн бүртгэлийн 30 хувьд	- Хугацаа болоогүй
2.4.5	Байгууллагын ББНШКомисс төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах	-	-Зохион байгуулсан ажлын үр дүнг тооцсон эсэх	2020 онд байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт гаргасан	Төлөвлөгөө хэрэгжсэн байна	<p>Хэлтсийн даргын тушаалаар Баримт бичиг нягтлан шалгах комиссыг шинээр томилон төлөвлөгөө гарган ажиллаж байна.2021 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гаргасан</p> <p>Хэлтсийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан.</p> <p>Хэлтсийн даргын 2020 оны А тушаал 27, Б тушаал 14 гарсныг сканнердаж, DVD хуулж архивын нэгж үүсгэсэн. Мөн 2021 оны 06 сарын 14-ний өдрийн байдлаар үндсэн үйл ажиллагааны асуудлаар гаргасан А тушаал 18, боловсон хүчний асуудлаар гаргасан Б тушаал 2, нийт 20 тушаал гарч, Хууль эрхзүйн хэлтэст эхний хагас жилийн байдлаар хянуулахаар хүргүүлээд байна.</p> <p>2009-2019 оны хоорондох байнга хадгалагдах 96, 70 жил хадгалагдах 24, түр хадгалагдах 355, устгах 95 баримтын жагсаалтыг бичиг хэргийн ажилтан бүртгэлийг гаргасан байна.</p> <p>2020 онд албан хаагчдаас холбогдох хууль, журмын дагуу хуваарь гарган, байнга хадгалагдах 8, түр хадгалах 60, 70 жил хадгалах 2 баримт нийт 70 баримтыг тус тус хүлээн авч бүртгэлд оруулаад байна.</p>
2.4.6	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP системийг хэрэглэх	-	- Албан хаагчид ERP системийг хэрэглэж хэвшсэн эсэх	Able систем ашигладаг	Хэлтсийн үйл ажиллагаанд ERP систем нэвтэрсэн байна.	Аймгийн хэмжээнд төрийн байгууллагууд ERP программыг дотоод албан хэрэгт ашиглаж эхэлсэн тул мэдээлэл технологийн ажилтан, бичиг хэргийн ажилтан хэлтсийн албан хаагчдад холбогдох сургалтыг зохион байгуулан албан хаагчдад ERP системд

						цагаа бүртгүүлэх, тайлан мэдээг дотоод программаар ирүүлэх зэргээр программыг хэрэглэж хэвшсэн. Мөн erp.emongolia програмд ирсэн, явсан бичгийг тухай бүр бүртгэж байна.
ГУРАВДУГААР ЗОРИЛГО: ХУУЛИАР ОЛГОСОН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ						
3.1	- Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Хуваарилагдсан төсвийн дагуу	- Сонгууль өгсөн сонгогчийн тоо - Тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн эсэх	-	Сонгуулийн хууль тогтоомж хэрэгжсэн байна.	Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хангах ажлын хүрээнд УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газар, Хяналт шалгалтын газар, Сонгуулийн ажлын хэсгийн 9 удаагийн өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн хүрээнд холбогдох ажлуудыг зохион байгуулж тайлан мэдээг илтгэх хуудсаар хугацаанд нь өгч ажиллалаа. Итгэмжлэгдсэн ажилтны эрх зүйн болон программын сургалтыг батлагдсан хуваарийн дагуу 2 удаа зохион байгуулсан. Сонгогчдын нэрийн жагсаалт, тоног төхөөрөмжийг сонгуулийн 52 хэсгийн хороонд хуулийн хугацаанд хүлээлгэн өгсөн Сонгуулийн тухай хуулийн дагуу сонгогчдын нэрийн жагсаалтад шилжин ирсэн 193, шилжин явсан 217, нас барсан 20, иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлт 2, түр хасав сэргээсэн 2 нийт 434 лавлагаагаар сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлтийг тусгалаа. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар нийт 30331 сонгогч санал өгөхөөс 16178 сонгогч 53,3 хувьтай өгсөн байна. Хурууны хээгээр, регистрийн дугаараар 410 , зөөврийн хайрцгаар 357, түр хасав сэргээсэн 3, эрэгтэй 7298 эмэгтэй 8880, 18-19 насны 687 ,

						20-24 насны 1204, 25-26 насны 1350, 30-34 1593, 35-39 насны 1752, 40-44 насны 1735, 45-49 насны 1659, 50-54 насны 1593ь 55-59 насны 1440, 60-64 насны 1246, 65-69 насны 721, 70 аас дээш 1198 сонгогчийн санал өгөх эрхийг баталгаажуулан ямар нэг алдаа зөрчил гаргалгүй ажилласан.
3.2	Авлигын эсрэг төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах	-	-Үр дүнг тооцож тайлагнасан эсэх	2020 оны Авлигын төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувь	Авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан мэдээ хүргэгдсэн байна.	Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн Авлигын эсрэг ажлын төлөвлөгөө, чиглэл зөвлөмжийн дагуу хэлтсийн авлигын эсрэг төлөвлөгөөг 8 арга хэмжээний хүрээнд төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна.
3.3	Хууль тогтоомжийн дагуу хууль хяналтын байгууллагад улсын бүртгэлийн мэдээллийн сангаас лавлагаа мэдээлэл хүргүүлэх.	-	-Хууль хяналтын байгууллагад гаргасан лавлагаа мэдээллийн тоо	2020 онд хууль хяналтын байгууллагын хүсэлтээр иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн нийт 509 лавлагаа гаргасан	Холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна.	Тус хэлтсийн хэмжээнд 06 сарын 14-ний байдлаар нийт 351 албан бичиг явснаас хууль хяналтын байгууллагуудад шаардлагатай лавлагаа мэдээллийг холбогдох бүртгэгч нар хуулийн хугацаанд нь гарган өгч хамтран ажиллалаа. Явсан бичгийн тоог харахад хууль хяналтын байгууллагад 125, УБЕГ-т 124, бусад байгууллагад 102 албан бичиг тус тус хүргүүлсэн байна. Мөн тайлант хугацаанд 257 албан бичиг ирснээс хариутай 127 албан бичиг байна. Үүнээс СДИХАШШүүх-18, ШШГГазар-24, Цагдаа-68, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-1, Авлигатай тэмцэх газар-5 нийт 105 албан бичиг хууль хяналтын байгууллагад, хариу хүргүүлсэн байна. Мөн ep.emongolia програмд ирсэн, явсан бичгийг тухай бүр бүртгэж байна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗОРИЛГО: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Зорилт 5. Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ.

4.5.1	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах.	-	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар хянуулсан эсэх; -Гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд холбогдох газруудад хүргүүлсэн эсэх;	2020 онд гүйцэтгэлийн төлөвлөгөө 92,6 хувьтай хэрэгжсэн.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.	2021 оны тус хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 зорилтын хүрээнд 64 арга хэмжээ төлөвлөн УБЕГазрын дарга болон Аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Засгийн газрын 2020 оны 205, 216, 217, 218 дугаар журмын хүрээнд хэлтсийн албан хаагчдад мэдээлэл өглөө. Сумдын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хэлтсийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг албан тушаалын тодорхойлолтод үндэслэн харьцуулах, тайланд анализ хийх боломжийг бүрдүүлэн нэг адил байлгах зорилгоор төлөвлөгөөг нийт 7 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ төлөвлөлөн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталлаа.	
4.5.2	Байгууллагын 2021 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх.	Батлагдсан төсвийн дагуу	- Сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж хуваарийн дагуу зохион байгуулсан эсэх; -Төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнасан эсэх -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Хэлтсийн сургалтын үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөний биелэлт 100%-тай хэрэгжсэн.	Төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулагдсан байна	Хэлтсийн сургалтын төлөвлөгөөний дагуу “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль” болон “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх, сонгогч шилжих журам”, “Итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулах, Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал”, “Төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалт, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах” сэдвүүдийн хүрээнд итгэмжлэгдсэн ажилтны эрх зүйн сургалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчийн	

						<p>бүртгэлийг нягтлан шалгахтай холбоотой анхаарах асуудлууд, мөн сонгогчийн бүртгэлийн программ хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны программын сургалтыг тус тус зохион байгууллаа. Тус сургалтад 52 хэсгийн хороонд ажиллах итгэмжлэгдсэн ажилтнууд хэлтсийн албан хаагчид, УБЕГазраас ирсэн сургалтын баг зэрэг нийт давхардсан тоогоор 134 албан хаагч оролцлоо.</p> <p>Мөн 2021 оны хэлтсийн албан хаагчдад чиглэл өгөх арга зүйгээр хангах нэгдсэн сургалтыг зохион байгуулсан.</p>	
4.5.3	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан сургалт, заавартай холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах.	-	-Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо; -Заавартай танилцсан албан хаагчийн тоо	-	Албан хаагчдыг бүрэн хамруулсан байна.	<p>Бүртгэлийн нэгдсэн сүлжээнд шинээр холбогдсон улсын бүртгэгчид мөн шинээр томилогдон ажиллаж байгаа Хулд, Луус, Говьугтаал сумдын улсын бүртгэгчдийг мэргэжил арга зүй, зөвлөмжөөр хангахын зэрэгцээ Сайнцагаан сумын улсын бүртгэгч дээр ажлын байранд онлайн программын дадлага хийлгэн бүртгэлийн хууль тогтоомж, анхан шатны нотлох баримтын бүрдүүлбэр, бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа программ хангамж дээр ажиллуулан чадваржуулах, мэдлэг олгох сургалтыг хийлгэж байна.</p>	
4.5.4	Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 92,6 хувь	Дэвшүүлсэн зорилтын хүрээнд батлагдсан төлөвлөгөө хэрэгжсэн байна	<p>УБЕГазраас 2020 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хэлтсийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарч хэлтсийн даргын зөвлөлийн хурал, хамт олны хурлаар танилцуулан төлөвлөгөө гарган</p>	

						<p>хэрэгжилтийг 100 хувь хангаж ажиллалаа. Бид 2021 оны улирал бүр шинэ зорилтыг дэвшүүлэн ажиллаж бүртгэлийн үйлчилгээг хурдтай, чанартай, хүртээмжтэй хүргэх, албан хаагчдын бүтээлч сэтгэлгээ, шинэ санал санаачлагыг дэмжих, тэднийг хөгжүүлэх, сургах ажлын байрны эрүүл, аюулгүй тав тухтай орчныг бүрдүүлж ажиллах зорилгоор</p> <p>1 дүгээр улиралд “Цахим мэдээллийн үйлчилгээ цаг хугацааны хэмнэлт”</p> <p>2 дугаар улиралд “Хурдтай бүртгэл-“Хүртээмжтэй бүртгэл”</p> <p>3 дугаар улиралд “Эерэг хандлага- эелдэг харилцаа”</p> <p>4 дүгээр улиралд “Ажлын байрны ая тух нийгмийн баталгаа ” зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Цаг үеийн нөхцөл байдалтай уялдан бүртгэлийн үйлчилгээ хууль тогтоомжийг олон нийтэд цахимаар нээлттэй, хүртээмжтэй хүргэх, сурталчлах, иргэдийг цаг хугацаа орон зайнаас үл хамааран үнэн зөв мэдээлэл авах боломжийг бүрдүүлж, халдвар, эрсдлээс урьдчилан сэргийлэх, иргэдийг цахимаар мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллалаа.</p>	
4.5.5	Хэлтсийн дотоод үйл ажиллагаа, албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, ажил үүргийг зөв зохистой хуваарилж ажиллах.	-	-Эцэг эхийн зөвлөл -Сургалт сурталчилгааны ажлын хэсэг -Спорт, урлаг, эрүүл мэндийн ажлын хэсэг - ББНШКомисс,	-	Хэлтсийн үйл ажиллагаа сайжирсан байна.	Хэлтсийн дотоод үйл ажиллагаа, албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажил үүргийг зөв зохистой хуваарилж хэлтсийн дотоод үйл ажиллагаа хяналтыг сайжруулах зорилгоор хэлтсийн даргын тушаалаар ажлын хэсгүүдийг шинээр томилон ажиллуулж байна.Үүнд:	

			Даргын зөвлөл, Ёс зүйн зөвлөл, Өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь - Хэрэгжүүлсэн ажлын тайланг 2 удаа хагас бүтэн жилээр тайлагнасан эсэх			<ul style="list-style-type: none"> - Даргын дэргэдэх зөвлөл - Ёс зүйн зөвлөл - Өмч хамгаалах зөвлөл - Баримт бичиг нягтлан шалгах комисс - Эцэг эхийн зөвлөл - Сургалт сурталчилгааны ажлын хэсэг - Спорт, урлаг, эрүүл мэндийн ажлын хэсэг <p>зэрэг ажлын хэсгүүдийг байгуулж тус бүр төлөвлөгөө гарган батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	
4.5.6	Нийтийн албанд албанд шинээр томилогдож байгаа болон албан хаагчдын ХАСХОМ мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлж ажиллах.	-	-Албан хаагчдын ХАСХОМ хугацаанд нь мэдүүлсэн эсэх	-	ХАСХОМ хугацаандаа мэдүүлж, тайлан мэдээ хүргэгдсэн байна	<p>Хэлтсийн төрийн захиргааны нийт 23 албан хаагчид 2020 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн.</p> <p>Аймгийн тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэст хэлтсийн албан хаагчдын хамаарал бүхий этгээдийн нэгдсэн судалгааг гаргаж өгсөн. Луус, Говьугтаал, Хулд сумын улсын бүртгэгчид шинээр томилогдсонтой холбогдох албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүллээ.</p> <p>"Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем"-д Сайнцагаан сумын улсын бүртгэгчийн регистрийн дугаар алдаатай байсныг Тамгын газарт албан хүсэлт, холбогдох нотлох баримтын хамт хүргүүлэн засварлуулсан.</p>	
4.5.7	Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион	-	- Байгууллагын нууцын тайланг хуулийн хугацаанд гаргаж хүргүүлсэн эсэх	-	Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж хэрэгжсэн байна	Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах 52 албан хаагчийн холбогдох мэдээллийг аймгийн Тагнуулын хэлтэст	

	байгуулах.					<p>хүргүүлэн дүгнэлтийг гаргуулан итгэмжлэгдсэн ажилтны гэрээ байгуулан, нууцын баталгаа гаргуулан ажиллалаа. Итгэмжлэгдсэн ажилтнуудад төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийг итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах хугацаандаа мөрдөж ажиллах талаар заавар зөвлөмж өгч ажилласан.</p> <p>Шинээр томилогдсон Луус, Хулд, Говьугтаал сумдын улсын бүртгэгчдээс нууцын баталгаа гаргуулан, ажлаас чөлөөлөгдсөн Говьугтаал, Хулд сумын улсын бүртгэгчид, чөлөөлөгдсөн хяналтын улсын байцаагчаас нууцын баталгааг бичгээр гаргуулан хууль тогтоомжийг таниулан ажиллалаа.</p>	
4.5.8	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих ажлыг сайжруулах.	-	-Иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн санал гомдлын тоо - Бүрэн шийдвэрлэгдсэн эсэх	150	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих ажлыг сайжруулсан байна.	<p>Иргэдээс бичгээр нийт 68 хүсэлт ирүүлсэн байна. Үүнээс иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 55 хүсэлт ирсэн нь иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн хөрвүүлэлтээс иргэдийн мэдээлэл алдаатай, орхигдсон учраас ургийн овог, эцэг эхийн мэдээлэл, төрөлтийн бүртгэл мэдээллийн санд ороогүй, ургийн овог зөрүүтэй, мөн овог нэрийн үсгийн зөрүүтэй, гэрлэсэн тухай бүртгэл мэдээллийн санд бүртгэлгүй, төрсөн он сар алдаатай зэрэг хүсэлтүүдийг холбогдох нотлох баримтын хамт хүлээн авч Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний улсын бүртгэлийн газарт холбогдох материалыг хүргүүлснээр мэдээллийн санд иргэдийн мэдээллийг засвар өөрчлөлтийн</p>	

						бүртгэлээр залруулан оруулж, хариуг иргэд утсаар болон өөрийн биеэр ирж авсан байна.	
4.5.9	Монгол улсын ерөнхийлөгчийн 2018 оны “Монгол бичгийн албан хэрэглээг нэмэгдүүлэх тухай”46 дугаар зарлигийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах.	-	- Албан хаагчдын дунд монгол бичиг сурах идэвхи, чармайлтыг дэмжих ажлыг зохион байгуулсан эсэх	Хэлтсийн албан хаагчдын ерөөний хаяг хос бичгээр бичиж байршуулсан.	Хэлтсийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг дээшилсэн байна.	Улсын хэмжээнд зохион байгуулагдсан Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаанд нийт албан хаагчдыг хамруулсан. Дундговь аймгийн Засаг дарга Ц Мөнхбат нь Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлийн дарга бөгөөд тус зөвлөлийн шийдвэрээр “ Монгол бичгээ эхлэн суралцах”цахим хичээлийг аймгийн хэмжээнд бүх төрийн албан хаагчдад явуулах зорилгоор “ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД” нэртэй фэйж хуудсанд байгууллагын албан хаагчдыг элсүүлэн монгол бичгийн цахим цуврал сургалтуудыг Боловсрол соёл урлагийн газраас явуулж байна. Байгууллага бүрт монгол бичгийн багш хуваарилан хөтөлбөр сургалтын хуваарийн дагуу 7 хоногт 1 удаа хичээллэж байна. Хэлтсийн албан хаагчид Монгол улсын гавъяат багш Д.Төмөрийн “Монгол бичгээ 15 хоногт бие даан сурах анхны хичээлүүд” ном, “Хүмүүн бичиг” сонинг захиалан албан хаагчид уншиж, мэдлэгээ дээшлүүлэхэд ашиглаж байна.	
4.5.10	Байгууллагын ил тод нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах.	-	- Байгууллагын ил тод нээлттэй мэдээллийг вэйбсайтад байршуулсан тоо	70 хувь	Байгууллагын ил тод байдал хангагдсан байна.	Байгууллагын ил тод байдал болон үйл ажиллагааг цахим хуудас болон пэйж хуудсанд тогтмол байршуулж ажиллаж байна. Аймгийн хэмжээнд хийгдсэн ажил болон улсын хэмжээнд явагдаж буй шинэ шийдэл, мэдээ мэдээллүүдийг цаг	

						<p>алдалгүй мэдээ бэлтгэн байршуулж ажиллаж байна.</p> <p>Байгууллагын хүний нөөц, санхүү, шилэн данс, сул орон тооны мэдээлэл ,мэдээ, тайланг тогтмол байршуулан ажиллаж байна. Хэлтсийн вэб хуудсанд мэдээ мэдээлэл, үйл ажиллагаа, ил тод байдлын 21 мэдээ бэлтгэн байршуулж Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс фэйсбүүк фэйж хуудсанд 14 мэдээ бэлтгэн байршуулж ажиллаа. Мөн хууль эрх зүй гэсэн цэс нэмж хууль тогтоомжуудыг байршуулав.</p>
4.5.11	<p>УБЕГазраас зохион байгуулж буй сургалтад хэлтсийн албан хаагчдыг хамруулах ажлыг зохион байгуулах.</p>	<p>Сургалтын төсвийн дагуу</p>	<p>-Сургалт явуулсан тоо -Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо</p>	<p>УБЕГазраас 18 удаа онлайн сургалт зохион байгуулсан 61 албан хаагч хамрагдсан</p>	<p>-Албан хаагчдын мэдлэг ур чадвар дээшилсэн байна</p>	<p>Улсын бүртгэлийн Ерөнхий газраас Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, цаашид анхаарах асуудал, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас аймаг болон дүүргийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн бүртгэгчдийг чадавхжуулах, бүртгэл хөтлөх болон цахим системийн боловсруулалтад анхаарах асуудлуудын хүрээнд зөвлөмж, чиглэл өгөх цахим сургалт, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хамтарсан ажил хэргийн уулзалтаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах талаар улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэст хүргүүлсэн Улсын</p>

						<p>бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 1/2215 дугаар чиглэлтэй холбогдуулан Хяналт шалгалтын газар, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас хамтран цахим сургалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдад сонгуулийн тухай хууль тогтоомжийг таниулах, зөвлөмж чиглэл өгөх, итгэмжлэгдсэн ажилтнуудтай гэрээ байгуулахад анхаарах асуудлаар зохион байгуулсан цахим сургалт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актад оруулсан нэмэлт өөрчлөлтүүд” сэдвийн хүрээнд нэгдсэн ойлголт, мэдээлэл өгөх тухай цахим сургалт зэрэг нийт 5 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор нийт 23 албан хаагч хамрагдсан.</p>
4.5.12	<p>Аймаг орон нутгаас зохион байгуулж буй сургалтад хэлтсийн албан хаагчдыг хамруулах ажлыг зохион байгуулах.</p>	-	<p>-Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо</p>	<p>Аймгийн ЗДТГазар,Мерит төслөөс зохион байгуулсан сургалтад 7 албан хаагч хамрагдсан.</p>	<p>Албан хаагчдын мэдлэг ур чадвар дээшилсэн байна</p>	<p>АЗДТГазрын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсээс Мерит төслийн хүрээнд зохион байгуулагдсан “ Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт,хяналт шинжилгээ, үнэлгээ”сэдэвт 4 модуль сургалт, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр зохион байгуулсан “Орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо ба нөлөөлөл” сэдэвт сургалт, Монгол улсын хүний эрхийн үндэсний</p>

						<p>комиссоос байгууллагын удирдах албан тушаалтнуудад зориулсан “Цар тахлын үеийн шийдвэр гаргалт ба хүний эрх” сэдэвт сургалт хэлэлцүүлэг,</p> <p>Мерит төслийн хүрээнд Дундговь аймгийн Монгол банкны салбар, МЭХ-ны Дундговь аймаг дахь салбарын 3 сарын 9-нд зохион байгуулсан "Өрхийн санхүүгээ удирдах нь амархан уу" сэдэвт сургалтанд хэлтсийн эмэгтэй ажилчид хамрагдлаа. Сургалт эмэгтэйчүүдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хуримтлалын ашиг тусыг таниулах, бага орлогоос хуримтлал үүсгэх арга, өрхийн төсвөө зөв удирдаж сурах сэдвүүдээр зохион байгуулагдсан сургалтад хэлтсийн 12 албан хаагчид оролцлоо.</p>	
Зорилт 6. Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.							
4.6.1	Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 сарын 30-ны өдрийн 230 дугаар тогтоолоор Улсын бүртгэлийн үйлчилгээний үнэ хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	- Бүртгэлийн үйлчилгээний үнэ хөлсний хэмжээг иргэдэд сурталчлах, үнийн талаарх мэдээллийг иргэдэд ил байрлуулсан эсэх	МУЗГазрын 2010 оны 237-р тогтоол	Шинэчлэгдсэн үнийн тарифаар үйлчилгээг хүргэж эхэлсэн байна	Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 сарын 30-ны өдрийн 230 дугаар тогтоолоор Улсын бүртгэлийн үйлчилгээний үнэ хөлсний хэмжээг шинэчлэн тогтоож 7 сарын 1-ны өдрөөс мөрдөх гэж байгаатай холбогдуулан үйлчилгээний үнийн мэдээллийг хэлтсийн вэйб хуудас, фэйж хуудсанд байршуулж улсын бүртгэгчдийг иргэд олон нийтэд сурталчлан сум орон нутгийнхаа мэдээллийн групп иргэдэд сурталчлан ажиллахыг чиглэл болгосон.	
4.6.2	Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эргэлтэд хяналт тавих.	-	-Баримт бичгийн эргэлтийн тоо; -Хугацаатай хариутай албан	2020 онд 713 албан бичиг явуулж ,463 албан бичиг	Хэлтсийн албан хэрэг хөтлөлт стандартын дагуу явагдсан байна	Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Иргэн, Эд хөрөнгө, Хуулийн этгээд, Санхүү, зэрэг газруудаас дотоод сүлжээгээр нууцын тайлан, одон	

			бичгийн шийдвэрлэлтийн хувь;	ирүүлснээс хариутай 239 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн.	<p>медалийн талаар, ХАСХОМэдүүлэг гаргах, шилэн дансны мэдээлэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн талаар, архивчийн судалгаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөл, дотоод журамд санал яаралтай гаргаж ирүүлэх зэрэг нийт 21 дотоод сүлжээгээр ирсэн мэдээллийг хугацаанд нь хүргүүлж ажилласан.Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл, архивийн статистик тоон мэдээ, үйлчилгээний орлогын тоон мэдээ, иргэний үнэмлэхийн тоон мэдээ зэргийг 72 удаа холбогдох газруудад хүргүүлж ажилласан.</p> <p>Мөн Иргэний улсын бүртгэлийн газраас дотоод сүлжээгээр Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой 12 заавар, зөвлөмж, чиглэлийг хүлээн авч шийдвэрлэж илтгэх хуудсаар тухай бүр хариуг хүргүүлж ажиллалаа.</p> <p>УБЕГазраас ирүүлж байгаа чиглэл, зөвлөмжийг тухай бүр улсын бүртгэгчдэд мэдээлэн хэрэгжүүлж, мөрдөж ажиллахыг албан хаагчдад үүрэг болгон хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийн бүртгэл хөтлөн хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Тус хэлтсийн хэмжээнд 06 сарын 14-ний байдлаар нийт 351 албан бичиг явснаас хууль хяналтын байгууллагуудад шаардлагатай лавлагаа мэдээллийг холбогдох бүртгэгч нар хуулийн хугацаанд нь гарган өгч хамтран ажиллалаа. Явсан бичгийн тоог харахад хууль хяналтын байгууллагад 125, УБЕГ-т 124, бусад байгууллагад 102 албан бичиг тус тус хүргүүлсэн байна. Мөн тайлант хугацаанд</p>
--	--	--	------------------------------	--	--

						<p>257 албан бичиг ирснээс хариутай 127 албан бичиг байна. Үүнээс СДИХАШШүүх-18, ШШГГазар-24, Цагдаа-68, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-1, Авлигатай тэмцэх газар-5 нийт 105 албан бичиг хууль хяналтын байгууллагад, хариу хүргүүлсэн байна</p> <p>2020 онд албан хаагчдаас холбогдох хууль, журмын дагуу хуваарь гарган, байнга хадгалагдах 8, түр хадгалах 60, 70 жил хадгалах 2 баримт нийт 70 баримтыг тус тус хүлээн авч бүртгэлд оруулаад байна.</p>	
4.6.3	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих.	-	-Үйлчилгээний стандартын хэрэгжилтийн хувь; -Ёс зүйн арга хэмжээ авагдсан албан хаагчдын тоо;	2020 онд 6 албан хаагч сахилгын шийтгэл тооцогдсон	Үйл ажиллагаандаа дүрэм, журмыг мөрдөж, стандартын зөрчил гараагүй байна.	<p>Хэлтсийн ёс зүйн зөвлөлийг хяналтын улсын байцаагчаар ахлуулан, хэлтсийн дарга,иргэн, эд хөрөнгийн улсын бүртгэлийн тасгийн дарга,ахлах бүртгэгч, улсын бүртгэгчийн бүрэлдэхүүнтэйгээр шинээр байгуулж 2021 онд хийх ажлын төлөвлөгөө, ёс зүйн зөвлөлийн ажиллах журам, албан хаагчидтай байгуулах ёс зүйн гэрээний загварыг хэлэлцэж баталлаа.</p> <p>Улсын бүртгэлийн хэлтсийн Албан хаагчидтай ёс зүйн гэрээ байгуулан ажиллаж, үүрэг хариуцлагыг дээшлүүлэн, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна.</p> <p>Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа, чадавхыг сайжруулах зорилготой албан хаагчдыг хамруулсан сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	

4.6.4	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд сайн дурын үндсэн дээр хамруулах ажлыг зохион байгуулах.	-	-Албан хаагчдыг сайн дурын үндсэн дээр эрүүл мэндийн үзлэгт хамруулсан эсэх;	-	Хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	<p>Коронавирусын өвчлөлтэй холбоотой тус хэлтсийн 27 албан хаагчид урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдлаа.</p> <p>Нийт амны хаалт 1996 ширхэг, гар ариутгагч санитол 35 л, резинэн бээлий 300 хос, нэг удаагийн малгай 50, ариутгалын спирт 2 литр, спирттэй нэг удаагийн сальфетка 10 хайрцаг, цэвэрлэгээний бодис жавельон 4л, нүүрний хаалт нүдний шил 25 ширхэг халдваргүйтгэл хамгааллын хэрэгсэл авч улсын бүртгэгч нарт гурван удаа тарааж олгосон. УБЕГазраас 600 маск, нүдний шил 6, нүүрний хаалт 5 ширхэг нийт 806.967 төгрөг үнэ бүхий халдваргүйтгэл хамгааллын хэрэгсэл өгсөн.</p> <p>Улсын бүртгэлийн хэлтсийн хоёр давхарын 87м.кв 7 өрөө, нэг цэгийн үйлчилгээний танхим, архивын өрөөнд ариутгал халдваргүйтгэлийн үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар 2 удаа хийлгэсэн.</p>	
4.6.5	Даргын зөвлөлийн болон бүх албан хаагчдын хурлын тэмдэглэл хөтөлж, гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих.	-	-Хөтөлсөн хурлын тэмдэглэлийн тоо; -Үүрэг даалгаврын тоо; -Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь;	2020 онд даргын зөвлөл 4 удаа хуралдаж тэмдэглэлээр албан хаагчдад үүрэг даалгавар өгч ажилласан.	Үүрэг даалгаврын биелэлт хангагдсан байна	Хэлтсийн даргын зөвлөлийг эхний хагас жилд 2 удаа хуралдуулан 2021 оны зорилго зорилт, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, албан хаагчдын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор хэлтсийн дотоод үйл ажиллагаатай холбоотой ажлын хэсгүүдийг байгуулан төлөвлөгөө боловсруулан ажиллах, ажлын хэсгүүдийн ажлыг тогтмолжуулах, үр дүнтэй ажиллах зэрэг асуудлаар санал, зөвлөмжүүдийг	

						хэлэлцлээ. Аймгийн Засаг даргын тамгын газраас 2021 онд хэлтэс агентлагийн дарга нарын хурлыг 14 хоногт 1 удаа хийдэг болсонтой уялдуулан хэлтсийн албан хаагчдын хурлыг мөн хугацаанд хийж байна. Хурлаар хэлэлцсэн асуудал, албан хаагчдад хүргэж байгаа мэдээ мэдээллийг хурлын тэмдэглэлээр баталгаажуулан үүрэг чиглэл өгч ажилласан.	
4.6.6	Улсын бүртгэлийн ерөнхий газраас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн даргын тушаал шийдвэрийг хяналтад авч бүртгэл хөтлөх.	-	-Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой даргын тушаал, шийдвэрийн тоо, хяналтад авсан эсэх;	2020 оны жилийн эцэст тус хэлтэст УБЕГ-ын даргын тушаал, үүрэг даалгаварыг бүрэн хэрэгжүүлж ажилласан.	Хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.	Хулд, Говьугтаал, Луус сумдын улсын бүртгэгчийг шинээр томилсон, хяналтын улсын байцаагчийг ажлаас чөлөөлсөн, хяналтын улсын байцаагчийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон зэрэг албан хаагчидтай холбоотой Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 5 тушаал, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр хугацаагаар зогсоосон сэргээсэн тухай 2 тушаал зэрэг нийт 7 тушаалыг хүлээн авч хэрэгжилтийг хангаж ажилласан.	
4.6.7	Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх.	-	Сар бүр иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх инфографик мэдээллийг бэлтгэн брошур хэлбэрээр байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт	2020 онд фэйсбүүк хуудас болон цахим хуудсанд 12 удаа байршуулсан.	Сар бүр мэдээлэл байршуулсан байна.	Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн сар бүрийн статистик тоон мэдээгээр 1-6 дугаар сарын инфографик мэдээллийг бэлтгэн “Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс” нээлттэй фэйж хуудас, Бүртгэлийн хэлтэс дотоод груп, Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс вэйб сайтад байршуулан мэдээллийг олон нийтэд хүргэн ажиллаж байна	

			байршуулсан тоо;				
4.6.8	Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох.	-	-Хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон тоо; -Шийдвэрийн мэдээлэл; -Хэрэг маргааны судалгаа эрх зүйн хэлтэст хүргүүлсэн байдал;	байхгүй	Хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, байгууллагын эрх ашгийг бүрэн хамгаалсан байна.	-Эхний хагас жилд Хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдсэн хэрэг маргаан гараагүй болно.	
4.6.9	Байгууллагын үйл ажиллагааг цахим, фэйсбүүк хуудсаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, телевиз радиогийн нэвтрүүлэгт оролцох	-	- Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахим хуудаст байршуулсан тоо; -Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тоо;	2020 онд хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг цахим болон фэйсбүүк хуудсанд 46 удаа байршуулсан. Орон нутгийн телевиз, сонинд 3 удаа мэдээлэл хийсэн.	Байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон цаг үеийн чанартай хийж хэрэгжүүлж буй ажлын талаар иргэд, олон нийт мэдээ мэдээлэлтэй болсон байна.	Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа иргэдэд ил тод нээлттэй, хүртээмжтэй хүргэх, хууль тогтоомжоо сурталчлах ажил ялангуяа иргэдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хувьд гол ажлын нэг бөгөөд сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан иргэдэд зориулсан мэдээ мэдээллийн ажил хорио цээрийн дэглэмийн үед хоцрох тасрах явдал гарч байна.Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилго нь иргэдэд эрх зүйн мэдлэг мэдээллийг цахим болон цахим бусаар хүртээмжтэй энгийн, хялбар ойлгомжтой аргаар хүргэхэд оршино гэж заасан байдаг. Иймд хөл хорионы үед тус хэлтсээс иргэдийн эрх зүйн мэдлэгт зориулан „ Бүртгэгчийн цахим зөвлөмж „ гэсэн цахим цуврал зөвлөмжийг 4 удаа, burtgel.gov.mn сайтаас иргэн, эд хөрөнгө,	

						<p>хуулийн этгээдийн бүртгэлийн 27 төрлийн лавлагаа, улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн нээлттэй мэдээллийг хэрхэн авах, газрын анхны бүртгэл зэрэг сэдвээр Livi- мэдээлэлийг Дундговь аймаг дахь улсын бүртгэлийн хэлтэс, бүртгэлийн хэлтэс фэйс хуудас, du.burtgel.gov.mn вэйб хуудсаар хүргэж ажиллалаа. „Бүртгэгчийн цахим зөвлөмж,, мэдээллийг 761 иргэн үзэж, сумдын бүртгэгчид өөрийн сумдын фэйж хуудсанд шэйр хийж бусдад түгээр зэргээр хууль тогтоомж, мэдээллийг сурталчлах ажлыг хийлээ. Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжид бүртгэлийн байгууллагын хийж гүйцэтгэж байгаа ажлаас ялангуяа сонгогчийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг хүргэж ажилласан.</p>
<p>Зорилт 7. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллана.</p>						
4.7.1	Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон ТББайгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх.	-	-Санал тавьж шийдвэрлүүлсэн эсэх	-	Орон нутгийн байгууллагатай хамтран ажилласан байна.	Тус аймгийн Засаг даргын захирамжаар “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарласан. ЭХЭУБГ-ын даргын 2021.04.14 –ны өдрийн 7/2734 тоот чиглэлийн дагуу засгийн газраас хэрэгжүүлж буй цогц төлөвлөгөөний хүрээнд жижиг дунд үйлдвэр,үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд олгох жилийн 3 хувийн хүүтэй ажлын байрыг дэмжих зээл, ипотекийн зээлийг арилжааны банкууд бүх салбар нэгжүүдээрээ дамжуулан олгож байгаатай уялдан ипотекийн гэрээ болон өмнө

					<p>бүртгүүлсэн гэрээний нэмэлт өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх иргэн, хуулийн этгээдийн хүсэлт сүүлийн өдрүүдэд огцом нэмэгдэж, иргэдийн бөөгнөрөл үүсгэх, халдвар хамгааллын дэглэм зөрчигдөх, короновируст халдвар тархах өндөр эрсдэл үүсээд байгаа учир энэ эрсдлийг бууруулж, улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай,хүртээмжтэй хүргэх зорилгоор онцгой нөхцөл байдлын хугацаанд иргэн, хуулийн этгээдийн банкттай байгуулсан барьцааны гэрээнүүдийг нэгтгэн банкны хариуцсан ажилтан улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхээр хандахад улсын бүртгэгч хүлээн авч бүртгээд банкны хариуцсан ажилтанд хүлээлгэн өгөх зэргээр хамтран ажиллаж байна.</p> <p>Дундговь аймгийн Тогтвортой амьжиргаа-3 төсөл, Модерн маркет ХХК-тай хамтран ажиллаж аймгийн баруун бүсийн 6 суманд “Бүртгэлийн нээлттэй мэдээллийн өдөрлөг” зохион байгууллаа. Тогтвортой амьжиргаа 3 төслөөс сумдад зохион байгуулсан өдөрлөгийн унаа, бензины зардлыг 100 хувь дааж бидний ажилд дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Аймгийн Засаг дарга, Аймгийн онцгой комиссоос гамшигт өртсөн малчдад туслах “ Нэг өдрийн цалингаа хандивлах аян” өрнүүлсэн. Тус аянд хэлтсийн албан хаагчид нэгдэж 600000 /Зургаан зуун мянган төгрөг/ төгрөг хандивласан.</p> <p>Дундговь аймгийн Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран төрийн албаны</p>	
--	--	--	--	--	--	--

						ерөнхий шалгалтад оролцсон 212 иргэний бүртгэлийн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлээр таниулан шалгалт өгөх эрхийг баталгаажуулан хамтран ажиллалаа	
4.7.2	Сумдын ЗДТГазрын дарга нартай хамтран ажиллах.	-	-Сумдын бүртгэлийн үйл ажиллагаанд тодорхой дэмжлэг авсан эсэх	-	Тодорхой асуудлыг шийдвэрлүүлсэн байна.	<p>Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг скайнердах, цахим архив үүсгэхэд зориулан Аймгийн Засаг даргаас, сумдын засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээнд тус аймгийн 8 суманд 3 үйлдэлт принтерийг шийдвэрлүүлэхээр тусгууллаа мөн Аймгийн Засаг даргын 2021 оны үйл ажиллагааны хөтөлбөр,2021-2024 оны үндсэн чиглэлд улсын бүртгэлийн байгууллагаас улсын бүртгэлийн үйлчилгээний танхимд төлбөр үйлчилгээний “Гэрэгэ” машиныг шийдвэрлүүлэх мөн мэдээллийн санд төрөлтийн бүртгэлд алдаатай бүртгэгдсэн 8200 иргэний бүртгэлийн зөрчлийг арилгах ажлуудыг хийхээр тусгуулсан.</p> <p>Сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга нарын сургалт 4 сарын 6-7-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сумдад сурталчлах, иргэдэд сургалт мэдээллийг хүргэх ажил босоо удирдлагатай байгууллагуудын мэргэжилтэн албан хаагчид санаачлагагүй, дутагдалтай байдаг талаар сумдын Тамгын газрын дарга нар газар мэдээлсэнтэй холбогдон улирал бүр улсын бүртгэгчдийн үйл ажиллагааг үнэлүүлэх 5 үзүүлэлтээр мэдээлэл</p>	

						солилцож хамтран ажиллахаар болсон.	
4.7.3	Монгол улсын “Иргэний андгай өргөх” ажиллагааг зохион байгуулах	150,0 хэлтсийн төсөв	-Хамрагдсан сурагчдын тоо -Хамтран ажилласан сургуулийн тоо	-	Иргэний үнэмлэхийн үнэ цэнэ, ач холбогдлыг ойлгуулсан байна.	- Хугацаа болоогүй	
4.7.4	Намрын дунд сарын шинийн 17-ны өдөр “Гэрлэх ёслол” –ын ажиллагаа зохион байгуулах	200,0 бусад эх үүсвэр	- Гэрлэлт батлуулсан хосын тоо	Аймгийн Онцгой байдлын газрын 6 албан хаагч, Сайнцагаан сумын 1 иргэний хүсэлтээр 7 гэрлэх ёслолын ажиллагааг зохион байгуулсан.	Гэрлэсэн хосууд бие биеэ хүндлэх, гэрлэлтийн үүрэг хариуцлагыг мэдсэн байна	- Хугацаа болоогүй	
Зорилт 8. Санхүү, төсвийн удирдлага болон төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.							
4.8.1	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах.	383 сая төгрөг	-Төсвийн гүйцэтгэлийн мэдээ хүргүүлсэн тоо -Төсвийн өр, авлага үүсгэсэн эсэх; -Төрийн аудитын шалгалтаар зөрчилгүй ажилласан эсэх;	2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан. 435 сая төгрөгийн төсвийг хууль журмын дагуу зарцуулан өр авлагагүй ажилласан.	Төсвийг үр ашигтай хуулийн дагуу зарцуулсан байна.	Батлагдсан төсвөөс 05-р сарын 31-ны байдлаар 174,376.3 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч, үүнээс цалин хөлсний зардалд 131,339.4 мянга, унаа хоолны зардалд 2,857.2 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 18,424.1 мянга, бичиг хэргийн зардалд 1,383.7 мянга, тээвэр шатахуунд 214.3 мянга, шуудан холбоонд 752.4 мянга, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 100.0 мянга, даатгалын зардал 120.0 мянга, тээврийн хэрэгслийн татвар 52.4, тээврийн хэрэгслийн оношилгоо зардал 22.0 мянга, дотоод албан томилолтын зардалд 24.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1,442.1 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 179.2 мянга, бусдаар	

						<p>гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, төлбөр хураамжийн зардалд 445.0 мянга, багаж техник хэрэгсэлийн зардалд 0 мянга, урсгал засварын зардалд 26.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 0 мянга, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 0 мянган төгрөг нийт 155,381.8 мянган төгрөг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 89.1% байна. УБЕГ-аас тус хэлтсийн 2021 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 70,000.0 мянган төгрөгөөр баталсан. 5-р сарын 31 байдлаар орлогын төлөвлөгөөгөөр 29,166.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээс, 41,462.6 мянган төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөөний биелэлт 142.1 хувь байна.</p> <p>2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар 2021 оны 1 дугаар сард аудит хийж санхүүгийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан.</p> <p>2021 онд сар шинийн баярыг тохиолдуулан 220.200 төгрөгийн дэмжлэгийг байгууллагын ахмад настангууддаа үзүүлсэн.</p> <p>Хэлтсийн даргын тушаалаар 7 албан хаагчийн цалингийн шатлалыг ахиулсан.</p>	
4.8.2	Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, тогтмолжуулах	-	<p>- Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь</p> <p>- Байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийн сантай эсэх;</p> <p>- Хэрэглэгдэж байгаа бүх тоног төхөөрөмжийн</p>	Байгууллагын эд хөрөнгийн тооллого, хүчингүй болгосон үнэт цаасны зарцуулалт, ашиглалтын хугацаа дууссан	Өмч хамгаалах зөвлөлийн ажил тогтмолжсон байна	<p>Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийг байгуулж 2021 онд хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөөг гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсанаар байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийн зурагжуулсан сантай болж хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмжийн</p>	

			ашиглалт үзүүлэлтийн судалгаа гаргасан эсэх	эд хөрөнгийг актлах зэргээр 3 удаа хуралдаж шийдвэр гаргаж ажилласан.		ашиглалт үзүүлэлтийн судалгааг нэгтгэн гаргалаа. Хэлтсийн эхний хагас жилийн хөрөнгийн тооллого хийх тухай тушаалыг гарган бараа материалын тооллогыг хийж байна.	
4.8.3	Байгууллагын үнэт цаасны зарцуулалт, тайлагналтад хяналт тавих	-	- Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг цаг тухайд хийсэн болон ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн эсэх; -Татан авсан, зарцуулсан үнэт цаасны тоо -Байгууллагын үнэт цаас, маягт болон бусад бараа материалыг хэмнэлттэй зарцуулсан болон батлагдсан төсөв хэмнэсэн эсэх;	Сар бүр үнэт цаасны зарцуулалтын тайлан гаргадаг	Үнэт цаасны зарцуулалт	2021 оны эхний хагас жилийн байдлаар УБЕГазрын олгосон үнэт цаас, маягтуудыг тухай бүр орлого авч сар бүр зарцуулалт, үлдэгдлийн мэдээ тайлан гаргаж, үйлчилгээний төлбөрийг төрийн сангийн дансанд төвлөрүүлэн сар бүр улсын төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна. УБЕГазрын Санхүү аж ахуйн хэлтэст сар бүрийн 2 ны дотор төсвийн гүйцэтгэлийн мэдээ, сар бүрийн 30 ны дотор бүртгэлийн үйлчилгээний орлогын мэдээг тус тус гарган хүргүүлэн ажиллаж байна. Улсын бүртгэгчидтэй үнэт цаасны зарцуулалтын тайланг сар бүрийн 25 нд хийж хэвшсэн бөгөөд иргэн, эд хөрөнгө , хуулийн этгээдийн үнэт цаасны тооцоог улсын бүртгэгчидтэй бүртгэлийн программд тулгалт хийж хүчингүй болгосон үнэт цаасыг хяналтын улсын байцаагч, байгууллагын өмч хамгаалах комиссоор оруулан бүртгэгчдийн алдаатай үйл ажиллагаанаас хүчингүй болсон үнэт цаасны төлбөрийг тухай бүр төлүүлэн хяналт тавин ажиллаж байна. Үнэт цаасны тайлан, үйлчилгээний орлогын тайлан, иргэний үнэмлэхийн тайланг тус бүр 5 удаа нэгтгэж холбогдох газруудад хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан.	
4.8.4	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг		- Байршуулсан шилэн дансны	2020 онд 162 мэдээллийг	Шилэн дансны хууль хэрэгжиж	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, Төсвийн тухай хууль, Нягтлан	

	хангаж ажиллах		мэдээллийн тоо; -Хугацаандаа байршуулсан эсэх;	хуулийн дагуу байршуулсан.	мэдээлэл ил тод байршигдсан байна.	бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилийг тус тус ханган ажиллаж байна. УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс зэрэг газруудад сар, улирал бүр тайлан, мэдээ, үнэт цаасны зарцуулалтын тайланг хуулийн хугацаанд хүргүүлж, баталгаажуулан харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж ажиллаж байна.
--	----------------	--	---	----------------------------	------------------------------------	--

Зорилт 9. Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит тогтмол хийж, үр дүнг сайжруулна.

4.9.1	Ерөнхий газрын дарга, Даргын зөвлөлийн хурал, Шуурхай хурлаас өгсөн үүрэг хэрэгжүүлж ажиллах.	-	-УБЕГазар, ИУБГазраас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлж ажилласан эсэх - Гүйцэтгэсэн үүрэг даалгавар, биелэлтийн тоо	УБЕГазар болон ИУБГазраас өгсөн албан бичгээр болон дотоод сүлжээгээр ирсэн 26 чиглэлийн хүрээнд холбогдох ажлуудыг зохион байгуулж тайлан мэдээг илтгэх хуудсаар хугацаанд нь өгч ажиллалаа	Мэдээ мэдээллээр үнэн зөв хангасан байна.	Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хангах ажлын хүрээнд УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газар, Хяналт шалгалтын газар, Сонгуулийн ажлын хэсгийн 9 удаагийн өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн хүрээнд холбогдох ажлуудыг зохион байгуулж тайлан мэдээг илтгэх хуудсаар хугацаанд нь өгч ажиллалаа Иргэний улсын бүртгэлийн газраас e-майлээр өгсөн иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоосон тухай УБЕГазрын даргын тушаал, 100-гаас дээш настны судалгааг ирүүлэх тухай, мэдээллийн санд тодорхойгүй төлөвтэй 9 иргэний бүртгэлийг тулган нягталж ирүүлэх тухай, Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн төлөвлөгөө, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийг харах эрхийг сумдад олгож байгаатай холбоотой зөвлөмж
-------	---	---	---	--	---	---

						зэргийг улсын бүртгэгчдэд мэдээлж хугацаатай тайлан мэдээг хуулийн хугацаанд хүргүүлж улсын бүртгэгчдэд тухай бүр заавар зөвлөмж өгч ажиллаж байна. Иргэний улсын бүртгэлийн газраас дотоод сүлжээгээр түр оршин суугчийн мэдээлэл, гаргаж ирүүлнэ үү гэсний дагуу сумдын улсын бүртгэгчдээс холбогдох хүснэгтийн дагуу мэдээллийг гаргаж хүргүүлсэн.	
4.9.2	Хэлтсийн албан хаагчдын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх.	-	- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 100 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу үнэлгээг хийсэн эсэх. -Үнэлгээ хийлгэсэн албан хаагчдын тоо	Үнэлгээний баг байгуулан журмын дагуу үнэлгээ хийсэн.	Бүрэн хангалттай 3, хангалттай 18	Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжилтийг ЗГХЭГазрын даргын 100 дугаар тушаалын 8 дугаар хавсралт маягтын дагуу гаргууллаа. Иргэн, Эд хөрөнгийн тасгийн дарга, ахлах бүртгэгчдийн тайлангийн хэрэгжилтийг зохион байгуулалтын нэгжийн тайлангийн загвар буюу 7 дугаар хавсралтын дагуу гаргуулсан. Албан хаагчдын тайлангийн үнэлгээг журмын дагуу үнэлгээний баг томилон ажиллуулахаар төлөвлөөд байна.	